



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/202

Номгон

Шар усны үерээс урьдчилан сэргийлэх
чиглэлээр авах зарим арга хэмжээний
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.б, 29.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Шадар сайдын 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн "Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамж"-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цаг агаарын дулааралттай холбоотойгоор цас ихтэй нутгууд, уулархаг газар, гуу, жалга, гол, мөрөн, нуурын цас, мөс эрчимтэй хайлах, мөсний нягт багасах үед иргэд явганаар болон тээврийн хэрэгслээр зорчин осолдох, хуурай сайраар шар усны үер буух аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдлыг хангах зорилгоор шар усны үер, мөс цөмрөх үерээс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг 2021 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 20 хүртэл 30 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2. Шар усны үер, мөс цөмрөх үерээс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамжийг нэгдүгээр, зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Цаг агаарын мэдээг орон нутгийн хэмжээнд нарийвчлан гаргаж, иргэдэд шуурхай хүргэх, багц мессежээр олон давтамжтайгаар дамжуулах, цасан бүрхүүл болон гол, нууруудын мөсний зузаанд хэмжилт хийж, болзошгүй эрсдэлийн судалгаа гаргаж аймгийн Онцгой комисст танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга (Ч.Оюунчимэг)-д,

4. Дээрх өдрүүдэд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, зам тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулж ажиллахыг Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Б.Оюутболд)-т,


1210505

5. Төв орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдийг гол, мөрөн, нуурын мөсөн дээгүүр зорихгүй байх талаар анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээг тогтмол хүргэж, баталгаагүй гарц, гарам дээр самбар байршуулж сэрэмжлүүлэх зэрэг шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлыг аймгийн Онцгой байдлын газар (хурандаа Ж.Алтангэрэл)-т,

6. Гол, мөрөн, нуурын арал, тохой, эрэг дагууд болон уулын ам, бэл, гуу, жалга, сувгийн ойролцоо айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг бууж суурьшихгүй байхыг анхааруулах, эрсдэл бүхий газар нутагласан айл өрхийн судалгааг гаргаж, мэдэгдэл хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх, эрсдэл бүхий газруудад урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг бүхий самбар байршуулах, хөдөлгөөнт эргүүлийг ажиллуулахыг сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

7. Аймгийн төвийн (Баянхонгор сум)-ын хэмжээнд Шар усны үерээс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 2,802,400 (хоёр сая найман зуун хоёр мянга дөрвөн зуун) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (М.Өнөржаргал)-д зөвшөөрсүгэй.

8. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар
сарын 22-ны өдрийн А/202 дугаар захирамжийн
нэгдүгээр хавсралт

ШАР УСНЫ ҮЕРИЙН АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Цаг агаарын дулааралттай холбоотойгоор цас ихтэй нутгууд, уулархаг газар, гуу, жалга, гол мөрөн, нуурын цас, мөс эрчимтэй хайлах, мөсний нягт багасах үед иргэд явганаар болон тээврийн хэрэгслээр зорчин осолдох, хуурай сайраар шар усны үер буух аюулаас урьдчилан сэргийлэх, амжиж анхааруулахад оршино.

Хоёр. Ерөнхий зүйл

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоол, Улсын их хурлын 2011 оны 22 дугаар тогтоол, Монгол улсын шадар сайдын 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан “Шар усны үерээс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамж”-ийг удирдлага болгон ажиллана.

Гурав. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах хугацаа

Урьдчилан сэргийлэх хөдөлгөөнт эргүүл ажиллуулах хяналтын арга хэмжээг 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдрөөс 4 дүгээр сарын 20-ны өдрүүдэд бүр 09:00 цагаас 22:00 цаг хүртэл зохион байгуулна.

Дөрөв. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний үндсэн чиглэл

1. Томоохон гол, мөрөн нуур, цөөрөм, үерийн эрсдэл бүхий газарт эргүүл, ажиллуулж, зорчиж байгаа болон амарч зугаалж буй иргэдэд сэрэмжлүүлэг, мэдээлэл өгч болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх;

Тав. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах бүрэлдэхүүн

Онцгой байдлын газраас 3 алба хаагч, 1 нэгж техник, Цагдаагийн газраас 3 алба хаагч, 1 нэгж техник, Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газраас 1-2 алба хаагч, Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 1-2 алба хаагч хамтран эргүүл хяналтын үйл ажиллагааг зохион байгуулна.

Зургаа. Урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдэх ажил

1. Томоохон гол, мөрөн, нуур, цөөрөм дагуу эргүүл ажиллуулж, амарч, зугаалж буй иргэдэд сэрэмжлүүлэг, мэдээлэл өгөх;

2. Дээрх байгууллагууд эргүүл жижүүрийн үүрэг гүйцэтгэх алба хаагчдыг томилгоожуулан хуваарь гарган баталгаажуулж, хуваарийн дагуу үүрэг гүйцэтгэх;

3. Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сэрэмжлүүлэг шторк бэлтгэж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл цахим сайтаар иргэдэд хүргэх;

4. Иргэд олноор цуглардаг амралт, зугаалгын газар, гол, мөрөн, нуур, цөөрөм, усны осол гарч болзошгүй газруудад үер, уснаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, тэмдэг, тэмдэглэгээ, самбарыг байрлуулж, хуучирч муудсан тэмдэг, тэмдэглэгээг сэргээх арга хэмжээг авах;

Долоо. Эргүүлийн хуваарь

№	Сар, өдөр Байгууллага	03.20	03.21	03.22	03.23	03.24	03.25	03.26	03.27	03.28	03.29	03.30	03.31	04.01	04.02	04.03	04.04	04.05	04.06	04.07
		1	Онцгой байдлын газар	■		■		■		■		■		■		■		■		■
2	Цагдаагийн газар		■		■		■		■		■		■		■		■		■	
3	Баянхонгор сум	■		■		■		■		■		■		■		■		■		■
4	Ус, цаг, уур орчны шинжилгээний төв		■		■		■		■		■		■		■		■		■	

Ес. Дүгнэх

Тус арга хэмжээг зохион байгуулсан талаарх талаарх тайланг аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх тасгийн baunkhongor@nema.gov.mn хаягаар цахим хэлбэрээр 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хүлээн авна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/202 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

1. ИРГЭД ОЛОН НИЙТЭД ТАРААХ МАТЕРИАЛ

Д/д	Сэрэмжлүүлэг материал	Тоо /ширхэг/	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Боршур	1000	1000	1.000.000
2	Нийт зардал		1000	1.000.000

2. ХӨДӨЛГӨӨНТ ЭРГҮҮЛИЙН ШАТАХУУНЫ ЗАРДАЛ

Д/д	100 км-д зарцуулах норм	Шатахууны үнэ /литр/	1 сар	Өдөр явах км	Нийт явах зам	Нийт дүн /төгрөг/
1	Пургон 18 л	1560	30 хоног	100 км	3000	842,400

3. Хоол хүнс

Д/д	Материалын нэр	Тоо ширхэг	/1 Сард/	1 удаа	Хооллох тоо	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Хоол	4 хүн	30	4	4 хүн 30 хоногт 120 хоол	8,000	960,000

4. НЭГДСЭН ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Материалын нэр	Нийт үнэ	Хянасан
1	2	3	4
2	Иргэд олон нийтэд тараах боршур	1.000.000	
3	Хяналтын ажлын хэсгийн шатахууны зардал	842,400	
4	Хоол хүнс	960,000	
3	Нийт зардал	2,802,400	

оОо